


# Сэдэв: Инкотермсийн FOB нөхцөл





## Усан онгоцны тавцанд хүргэх


1. Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг “худалдан авагчийн санал болгосон нэр бүхий ачаалах боомтод байрлах усан онгоцны тавцанд” хүргэх нөхцөл.
2. Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг усан онгоцны тавцанд хүргэснээр алдагдал, эвдрэл гэмтлийн эрсдэл худалдан авагч талд шилждэг.
3. Энэ нөхцөлийг зөвхөн далайн болоод дотоодын усан тээвэрт ашиглана.



Ачаалах усан онгоцны тавцан

Худалдагч нь бараа,  
бүтээгдэхүүнийг  
худалдан авагчийн  
санал болгож сонгосон  
усан онгоцны тавцанд  
хүргэнэ.

анхдагч тээвэрлэгч




FOB нөхцөлөөр худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг “худалдан авагчийн санал болгосон нэр бүхий ачаалах боомтод байрлах усан онгоцны тавцанд” хүргэнэ. Худалдан авагч аль боомтод байрлах ямар нэртэй усан онгоцонд бараа, бүтээгдэхүүнийг хүргэхийг санал болгодог.

Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг усан онгоцны тавцанд хүргэснээр алдагдал, эвдрэл гэмтлийн эрсдэл худалдан авагч талд шилждэг.

- Талууд даатгалын үүргийг бие биенийхээ өмнө хүлээдэггүй.
- Талууд хүргэлт хийх *“нэр бүхий ачаалах боомтын усан онгоцыг”* нарийвчлан тохиролцох шаардлагатай.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг боомт хүртэл тээвэрлэж усан онгоцны тавцанд хүргэх анхдагч тээвэрлэлтийн гэрээг худалдан авагчийн зардал, эрсдлээр хийнэ.
- Худалдагч боомтод хүргэгдэн ирсэн ижил бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч усан онгоцны тавцанд хүргэж бэлэн болгож болдог. Ийм нөхцөл байдал нь талууд түүхий эдийн худалдаа хийж байгаа үед гардаг.
- Худалдан авагч импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.

# FOB НӨХЦӨЛИЙН БУДУУВЧ ЗУРАГЛАЛ



## Хүлээх үүрэг хариуцлага, зардал

## ХУДАЛДАГЧ ХУДАЛДАН АВАГЧ

|   |   |   |
|---|---|---|
| 1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго                     | ✓ | ✗ |
| 2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт                    | ✓ | ✗ |
| 3. Бараа, бүтээгдэхүүн хүргэлт хийгдсэнийг мэдэгдэх               | ✓ | ✗ |
| 4. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх | ✗ | ✓ |
| Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих                                   | ✓ | ✗ |
| Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах                               | ✗ | ✓ |
| 5. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх                           | ✗ | ✓ |
| Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах                           | ✗ | ✓ |
| 6. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч руу)- ийг гэрээлэх, төлөх    | ✗ | ✓ |
| Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах                           | ✗ | ✓ |
| 7. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт                     | ✗ | ✓ |
| 8. Даатгал  | ✗ | ✗ |

# FOB БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД



Худалдагч      Худалдан авагч

| Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, өрсдэл | Бүх төрлийн тээвэр |      |        |        |          |          |            | Далайн болон дотоодын усан |      |        |        |
|---|--------------------|------|--------|--------|----------|----------|------------|----------------------------|------|--------|--------|
|   | EXW                | FCA  | CPT    | CIP    | DAT      | DAP      | DDP        | FAS                        | FOB  | CFR    | CIF    |
| Зардлын харьцуулсан хэмжээ                        | \$                 | \$\$ | \$\$\$ | \$\$\$ | \$\$\$\$ | \$\$\$\$ | \$\$\$\$\$ | \$\$                       | \$\$ | \$\$\$ | \$\$\$ |
| Барааны баглаа боодол                             | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Барааны гэмдэглэгээ, шоошго                       | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Эскапортын зөвшөөрөл                              | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Ачаа дамжуулагчийн төлбөр                         | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Үндсэн тээвэрлэгчтэй үүсгэх                       | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Үндсэн терминалын хураамж                         | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Усан онгоцонд ачуулах хураамж                     | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Усан тээвэр/агаарын тээвэр                        | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Эскапортын бараа дамжуулагчийг сонгох             | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Далайн даатгал                                    | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж        | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Очих газрын терминалын хураамж                    | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Тээвэрлэгчийг сонгох                              | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Хилээр зорх шаардлагууд                           | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Гаалийн үзлэг шалгалтын төлбөр                    | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Гаалийн хураамж, татвар                           | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Худалдан авагчтэй үүсгэх                          | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |
| Ачааг буулгах                                     | Худалдагч          |      |        |        |          |          |            | Худалдан авагч             |      |        |        |



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

